

**“ХҮҮХЭД ХӨГЖЛИЙН ОРЧИН ҮЕИЙН АСУУДЛУУД-2018”
СЭДЭВТ ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛААС ГАРГАСАН**

ЗӨВЛӨМЖ

Монголын хүүхдийн ордноос түүхт 60 жилийн ойн хүрээнд 2018 оны 10 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулсан Олон улсын эрдэм шинжилгээний хуралд манай улсын төрийн байгууллага, яамд, хууль сахиулах байгууллага, их, дээд сургуулиуд, эрдэмтэн судлаачид, эрдэм шинжилгээний хүрээлэн, төв, төрийн бус байгууллага зэрэг 40 гаруй байгууллагын 80 орчим эрдэмтэн, судлаач, мэргэжилтэн, практикийн ажилтнууд болон ОХУ, БНХАУ, БНСУ, Япон, Колумб, Энэтхэг, Турк, Тайланд зэрэг гадаад орны 20 гаруй эрдэмтэн, судлаачид Монгол Улсад суугаа дипломат байгууллага, Монгол дахь НҮБ-ын Хүүхдийн сан, Дэлхийн зөн Монгол олон улсын байгууллага, Кристиан Нобелийн сан зэрэг олон улсын байгууллагын төлөөлөгчид оролцож илтгэл тавилаа.

Хурал нь шинжлэх ухааны судалгааны үр дүнд суурилсан хүүхдийн хөгжил, хамгааллыг дэмжих, хүүхэд бүрэн эрхээ эдэлж, сурч боловсрох, эрүүл таатай амьдрах орчныг бий болгох олон талын арга зүйг хэрэглээнд нэвтрүүлэх бодлогыг тодорхойлоход хувь нэмэр оруулах зорилгоо амжилттай хэрэгжүүллээ.

Олон улсын эрдэм шинжилгээний хуралд гадаадын болон манай улсын судлаачдын 68 эрдэм шинжилгээний өгүүллэг, илтгэл ирснээс үндсэн хуралдаан болон 4 салбар хуралдаанд нийт 34 илтгэлийг хэлэлцүүллээ. Олон улсын эрдэм шинжилгээний хаалтын хуралдааны үеэр оролцогчдоос гарсан санал, дүгнэлтэд үндэслэн хүүхдийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаанд нэн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлагатай асуудлаар дараах зөвлөмжийг гаргав.

Нэг. Эрдэм шинжилгээ, судалгааны чиглэлд:

1. Хүүхэд, өсвөр үеийнхний бие бялдрын өсөлт, амьдралын хэв маяг, танин мэдэх хөгжлийн үе шат хамаарлын судалгааг цаашид үндэсний хэмжээнд өргөтгөх тэдгээрт нөлөөлж буй биологийн ба орчны үзүүлэлтүүдийг нийгэм, сэтгэл зүйн хүчин зүйлүүдтэй холбон тодорхойлох, иж бүрэн судалгаа хийхэд судлаачдын анхаарлыг хандуулах;
2. Судалгааны ажлын судлах асуудлын хүрээг тодорхой болгож, боловсролд тохиолдож байгаа асуудлуудаас тулгамдсаныг нь олж харж зөрчил бэрхшээлийн учир шалтгааныг бодиттойгоор илрүүлж, шийдвэрлэх арга замыг шинжлэх ухааны үндэслэлтэй гаргах;
3. Монгол хүүхдүүдийн амжилттай оролцож буй дотоод болон гадаадын олон улсын чанартай томоохон уралдаан тэмцээнд гаргаж буй амжилтыг сурталчлах, ялангуяа оюун ухаан, сэтгэлгээний салбарын амжилтын уг үндэсийг судлах, дагалдах болон мөшгих судалгааг эрчимтэй хийж, туршлага, арга замыг олон нийт, хүүхдүүдэд сурталчлан таниулах ажлыг өргөтгөх;
4. Хүүхдийн хөгжлийн тулгамдсан асуудлаар гадаадын судлаачидтай хамтын судалгааг өрнүүлэх;
5. Хүүхдийн хөгжлийн орчин үеийн асуудлаар хийгдэх хамтын судалгааг дэмжих, санхүүгийн туслалцааг Засгийн газар, нийслэл, аймаг, орон нутгийн төрийн байгууллагаас тогтмол үзүүлж байх;

Хоёр. Үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт:

6. Хүүхдийн хөгжил, оролцоо, хамгааллын асуудалд цогцоор анхаарах. Хүүхдийн хөгжлийг дэмжих, оролцоог хангах чиглэлээр тодорхой удирдамж, заавар боловсруулах, хүүхэд хамгааллын үйлчилгээний стандартыг боловсруулан үйлчилгээний төрөл, хэлбэрийг нэмэгдүүлэх;
7. ЕБС-д хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэхдээ хүүхэд, эцэг эх, олон нийтийн санал санаачлагыг тусгах, хүүхэд хамгааллын тулгамдсан асуудлыг шийдвэрлэхдээ төлөөллийг оролцуулдаг байх, үүрэг оролцоог тодорхой болгох
8. Хүүхдэд эрүүл мэнд, сэтгэл зүй, сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудын салбар хоорондын уялдаа холбоог сайжруулах;
9. Судалгаанд сууринсан бодлого түүнээс улбаалсан үйл ажиллагаануудыг төрийн болоод төрийн бус байгууллагуудын хооронд уялдаа холбоотойгоор зохион байгуулах, үр дүнд хяналт тавин ажиллах;
- 10.Хэвлэл, мэдээллийн байгууллагууд хүүхдийн хөгжлийг дэмжих, тэдэнд мэргэжлийн чиг баримжаа олгох асуудлыг нийтлэлийн бодлогодоо тусган тогтмол, идэвхтэй ажиллах

Гурав. Хүүхэд хөгжил, хамгааллыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

- 11.Хүүхэд хамгааллын хууль эрх зүйн орчинг хамтын оролцоотойгоор улам бүр бэхжүүлэх, олон улсын туршлагаас суралцах;
- 12.Хүүхдийн эрхийг хамгаалан, хүмүүжлийн үйл ажиллагаанд байгууллагуудын оролцоог эрс нэмэгдүүлэх, эцэг эхчүүдийн сурган хүмүүжүүлэх мэдлэгийг байнга ахиулахад сургууль, төрийн бус байгууллагууд тодорхой үүрэг гүйцэтгэх;
- 13.Монголын Хүүхдийн ордныг түшиглүүлэн хүүхдийн авьяас билгийг нээн илрүүлэх, хөгжүүлэх “Монгол хүүхэд судлалын төв”-ийг төрийн дээд байгууллага болон шууд харьяаны төрийн байгууллагын дэмжлэгтэйгээр бий болгох, Судлалын төвийг судалгааны арга зүй, сургалт, сурталчилгаа мэдээллийн гэсэн чиглэлээр ажиллуулах
- 14.“Монгол хүүхэд судлалын төв”-ийн үйл ажиллагааг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулах;
- 15.Хүүхдийн чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх орчин, нөхцлийг бүрдүүлэх ингэхдээ бүх хүүхэд хамрагдах боломжтой, хүүхдийн хөгжлийг дэмжсэн үйл ажиллагааг боловсролын үйлчилгээний түвшинд хөгжүүлэх;
- 16.Хүүхдийн хөгжлийн орчин үеийн асуудлаарх хурлыг тогтмолжуулж, тодорхой чиглэлээр зохион байгуулдаг уламжлал тогтоох;

Олон улсын эрдэм шинжилгээний хурлын оролцогчид

Монгол Улс, Улаанбаатар хот

2018 оны 10 дугаар сарын 10-ны өдөр